БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2024.08.05 № 627

танай ____________ны № ____________т

БУЛГАН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021301

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Монгол ардын намын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монгол ардын намын мөрийн хөтөлбөр (..20.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Монгол ардын намд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРОО

БУЛГАНЫ СЭРГЭЛТ

**2024-2028**

# БУЛГАН АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

БУЛГАН АЙМАГ 2024 ОН

## АГУУЛГА

**1. БУЛГАНЫ ИРЭЭДҮЙ – БОЛОВСРОЛТОЙ, ЭРҮҮЛ БУЛГАНЧУУД ..... 2**
1.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж ..... 2
1.2. Эрүүл мэнд ..... 3
1.3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, нийгмийн хамгаалал ..... 3
1.4. Соёл, урлаг, спорт ..... 4
**2. АЙМГИЙН ХӨГЖЛИЙГ ӨРХ БҮРД - ОРЛОГОТОЙ БУЛГАНЧУУД ..... 5**
2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бодлогоор дэмжих. ..... 5
2.2. Дэд бүтэц, эрчим хүч, газар зохион байгуулалт ..... 6
2.3. Орон сууцтай Булган ..... 6
2.4. “Шинэ хоршоо” хөдөлгөөн: ..... 7
2.5. Хөдөлмөр эрхлэлт : ..... 7
**3. ШУДАРГА ЗАСАГЛАЛ – ХАРИУЦЛАГАТАЙ БУЛГАНЧУУД ..... 8**
3.1. Иргэдэд ойр төрийн үйлчилгээ ..... 8
3.2. Хүний эрх, иргэний үүрэг ..... 8
3.3. Шударга, хариуцлагатай нутгийн удирдлага ..... 8
**4. НОГООН ХӨГЖИЛ – ЭКО БУЛГАНЧУУД ..... 9**
4.1. Байгаль орчин ..... 9
4.2. Хариуцлагатай уул уурхай ..... 10
4.3. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал ..... 10
4.4. Ногоон байгууламж ..... 11
**5. БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ – АЗ ЖАРГАЛТАЙ БУЛГАНЧУУД ..... 12**
5.1. Бүсчилсэн хөгжил – Булганы сэргэлт ..... 12
5.2. Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр ..... 12
5.3. Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл ..... 13
5.4. Амар тайван, аюулгүй аймаг ..... 14
5.5. Эрүүл идэвхтэй амьдрал ..... 14
**6. БУЛГАНЫ СЭРГЭЛТ – СУМЫН ХӨГЖИЛ ..... 15**

6317144798
ПОА0048 3190269

## БУЛГАНЫ СЭРГЭЛТ
## 2024-2028

# 1. БУЛГАНЫ ИРЭЭДҮЙ – БОЛОВСРОЛТОЙ, ЭРҮҮЛ БУЛГАНЧУУД

## 1.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж

1.1.1. Сургуулийн өмнөх 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулна.

1.1.2. СӨБ-ын хувилбарт сургалтыг дэмжин багш нарыг бэлтгэн чадавхжуулж, хөдөөгийн багт зуны бүлэг ажиллуулах арга хэмжээг авч цэцэрлэгийн хамрагдалт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.3. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны сурч боловсрох нөхцөл, эрүүл аюулгүй байдлыг ханган, бүрэн камержуулан гэрэлтүүлэг хийж, хатуу, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийн хангалтыг үе шаттайгаар хийнэ.

1.1.4. Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.1.5. Цэцэрлэгийн хоол болон ЕБС-ийн үдийн хоолны орц найрлагыг нэмэгдүүлж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.1.6. Цэцэрлэг, сургуулийн тогооч нарыг чадавхжуулан, сургуульд хоол зүйч ажиллуулна.

1.1.7. Цэцэрлэг, сургууль, дотуур байр, Политехник коллежийн барилгад үе шаттайгаар их засвар хийж, өргөтгөх, шинээр барих асуудлыг судлан шийдвэрлэнэ.

6317144798
ПОА0048 3190269

1.1.8. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг сайжруулж, багш нарыг гадаад дотоодын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.9. Багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулахад орон нутгийн дэмжлэг үзүүлэн түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулна.

1.1.10. Багш, сурагч, оюутан болон насанд хүрэгчид гэсэн ангиллын “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг 4 жилийн хугацаанд тогтвортой, тасралтгүй хэрэгжүүлнэ.

1.1.11. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт аймаг орон нутгийн түүх, уламжлалт соёл, эрүүл мэндийн боловсрол олгох агуулгыг оруулж амьдралын зөв дадалд сургана.

1.1.12. Сургуулиудад байгалийн ухаан, техник, технологийн хичээлийн кабинет, туршилтын талбайг үе шаттайгаар байгуулна.

1.1.13. Жил бүр 12 дугаар анги төгсөгчдөөс аймагт нэн шаардлагатай мэргэжлээр гадаадын их дээд сургуульд 160- аас доошгүй оюутныг сургана.

1.1.14. Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, мэргэжлийн нэр хүндийг өсгөхийн зэрэгцээ хариуцлага, ур чадварыг дээшлүүлэн, олимпиад, тэмцээн, ЭЕШ-д онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.15. Боловсрол, шинжлэх ухааны газрын чадавхыг дээшлүүлж, үйл ажиллагааг өргөтгөн багш бэлтгэдэг их, дээд сургуулиудтай түншлэлийн гэрээтэй ажиллахыг дэмжинэ.

1.1.16. Аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн барилгын асуудлыг шийдвэрлэнэ.

### 1.2. Эрүүл мэнд

1.2.1. Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилтот арга хэмжээ, төслийг хэрэгжүүлнэ.

1.2.2. Иргэдийн эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, чанартай, хүртээмжтэй зохион байгуулж, үзлэгт орох иргэдийн хамрагдалтыг 50,0 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.

1.2.3. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, эрт илрүүлэх "Эрүүл шүд, эрүүл хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.4. Их эмч, сувилагч нар болон салбарын дутагдалтай хүний нөөцийг бэхжүүлэхэд анхаарч, гадаад, дотоодод бэлтгэж, нийгмийн хангамжийг сайжруулна.

1.2.5. Эмч, сувилагчдын ажлыг бодитоор үнэлж, хэвийн нөхцөлд ажиллах боломжийг бүрдүүлж, орчин, хангамжийг сайжруулан сум, орон нутагт ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг мэргэшил дээшлүүлэх, дараагийн шатлалд сургах, чадавхжуулах тал дээр хууль эрхзүйн хүрээнд дэмжих бодлого баримталж, тусгай хөтөлбөр боловсруулан ажиллана.

1.2.6. Эмч, мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэн "Түрээсийн орон сууц" хөтөлбөрт хамруулна.

1.2.7. Нэгдсэн эмнэлгийг оношилгоо эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг бэлтгэнэ.

1.2.7.1. Төрөх, эмэгтэйчүүд, бөөр шээсний замын оношилгоо, эмчилгээний дурангийн мэс заслын иж бүрдэл бүхий аппарат

1.2.7.2. Цээжний гэмтэл, үе солих хагалгааны иж бүрдэл

1.2.7.3. Биохими, шээсний шинжилгээний автомат анализатор

1.2.7.4. Дүрс оношилгооны аппарат /рентген, эхо/

1.2.7.5. Авто машин дээр суурилагдсан явуулын рентген аппарат

1.2.8. Аймгийн төвд 80 ортой нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгыг барина.

1.2.9. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт алсын зайн оношилгоо, эмчилгээг хөгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цахимжилтыг төгөлдөржүүлнэ.

1.2.10. Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын ЭМТ-ийн барилгад үе шаттайгаар их засвар хийнэ.

1.2.11. Хүн амд сувиллын болон үндсэн нарийн тусламж үйлчилгээ үзүүлдэг ортой хувийн эмнэлэг, сувилал байгуулахыг бодлогоор дэмжинэ.

1.2.12. "Элэг бүтэн Монгол", "Умайн хүзүүн хавдаргүй Монгол" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.13. Аюулгүй, зайлшгүй шаардлагатай эмээр хүн амыг хангах "Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмж" хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлнэ.

### 1.3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, нийгмийн хамгаалал

1.3.1. Өрх бүр ургийн бичгээ хөтлөх санаачилгыг дэмжиж, хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, "Чанартай амьдрал-Аавуудын оролцоо" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.3.2. Хүүхэд, залуучуудыг аймаг орон нутгаараа бахархах, эх оронч үзэл, зөв хандлагатай иргэн болгох үзлийг дэмжсэн арга хэмжээг зохион байгуулна.

1.3.3. Аймгийн хүүхдүүдийн урлаг, спортын авьяасыг хөгжүүлэн сурталчилж,

улсын болон олон улсын чанартай спорт, урлагийн арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

1.3.4. Сургууль, цэцэрлэгийн орчны хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан орчныг шийдвэрлэж, хүүхэд бүрийг эрх тэгш суралцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.3.5. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдалд дүгнэлт хийж, хүчирхийллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хамгаалах түр байрыг тогтмол ажиллуулан сумын “хамтарсан баг” -уудыг чадавхжуулан дэмжиж ажиллана.

1.3.6. Аймгийн хүүхэд, залуучуудын онцлогт тулгуурлан бүсийн хэмжээнд тодорхой төрлүүдээр тэргүүлэх зорилтыг дэвшүүлж, “Анхдагчид” хүүхэд хөгжлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.3.7. Хүүхдийн “Жаргалант” зуслангийн үйл ажиллагааг өргөтгөж, хөтөлбөр сургалтуудыг чанаржуулан, хойд бүсийн ногоон хөгжлийн загвар зуслан болгож, хүүхэд бүр зуслангийн хөтөлбөрт хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

1.3.8. Хүүхдийн тоглоомын талбайн арчлалт үйлчилгээг сайжруулж, тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангана.

1.3.9. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, орон нутагт геронтологийг бодлогоор хөгжүүлнэ.

1.3.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн туслах үйлчилгээг бодлогоор нэвтрүүлнэ.

1.3.11. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоог бууруулна.

1.3.12. Хүүхэд, залуучуудын соёл, амралтын хүрээлэнгийн тохижилтыг хийж, үйл ажиллагааг идэвхжүүлж, орчин цагийн залуус, иргэдийн хэрэгцээт олон төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

**1.4. Соёл, урлаг, спорт**

1.4.1. Аймгийг сурталчлах "Булганы сэргэлт" соёл, урлаг, спортын өдөрлөгийг Эрдэнэт, Улаанбаатар хотод зохион байгуулна.

1.4.2. Орон нутгаас олдсон түүх, археологийн олдворуудыг аймагтаа татан авах, музейн сан хөмрөгт хадгалуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах бүтээгдэхүүн болгож гадаад, дотоодын үзэгчдийн тоог нэмэгдүүлнэ.

1.4.3. Аймгийн нутаг дэвсгэр дээр байгаа Түүх соёлын үл хөдлөх дурсгалын нөхцөл байдлын шинжилгээ, эрсдэлийн судалгаа хийж, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

1.4.4. Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлж, төлөвшүүлэх “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.4.5. ХЖТ, Музей, Номын сан, сумын Соёлын төвүүдэд шаардлагатай байгаа техник хэрэгсэл, тохижилтын ажлуудыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

1.4.6. Соёлын байгууллагуудын гадаад харилцааг хөгжүүлж, хүний нөөцийг бэлтгэх, дотоод, гадаадад сургаж, нийгмийн баталгааг хангах хүрээнд түрээсийн орон сууц хөтөлбөрт хамруулна.

1.4.7. Хөгжимт жүжгийн театрын урын сангийн шинэ бүтээлд санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлж, уран бүтээлчдийг дараагийн шатанд гарч хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлж, дотоод, гадаадын уралдаанд оролцоход орон нутгийн зүгээс дэмжих бодлого баримтлахыг сацуу соёлын үйлдвэрлэлийг дэмжиж

хөгжүүлнэ.

1.4.8. Уран бүтээлийн чанарт тавих шаардлага, хяналтын системийг сайжруулж, шилдэг бүтээл болон улсын, олон улсын чанартай уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийг орон нутгийн түвшинд шагнаж урамшуулах бодлого баримталж, дэмжиж ажиллана.

1.4.9. Аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилгыг барина.

1.4.10. Орчин үеийн стандартад нийцсэн Музейн барилгыг шинээр барьж, үзүүлэг дэглэлтийг аймгийн 90 жилийн ойд зориулж шинэчилнэ.

1.4.11. Аймаг, сумын Номын сангийн фонд баяжилтын төсөв, цахим сан хөмрөгийг нэмэгдүүлнэ.

1.4.12. Нийтийн биеийн тамирыг дэмжих хүрээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлж, нийтийн биеийн тамирын орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4.13. Амжилт гаргасан дасгалжуулагч, тамирчдыг урамшуулан шигшээ багийн тамирчдын гадаад харилцааг хөгжүүлэх, хамтарсан сургуулилалт хийх боломжийг хангаж, гадаад, дотоодын тэмцээнд оролцох боломжийг дэмжин өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.4.14. Үндэсний спортыг хөгжүүлэхийн зэрэгцээ, тэдний залгамж халааг бэлтгэх хүрээнд спортын холбоодтой түншлэлийн гэрээ байгуулж ажиллана.

1.4.15. Мэргэжлийн спортыг төрөл бүрт нь дэмжиж, шинэ залуу үеийг бэлтгэнэ.

6317144798

## 2. АЙМГИЙН ХӨГЖЛИЙГ ӨРХ БҮРД - ОРЛОГОТОЙ БУЛГАНЧУУД

### 2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бодлогоор дэмжих.

2.1.1. Бизнесийн салбарт төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчим баримталж, төр, захиргааны байгууллагын оролцоог хязгаарлана.

2.1.2. Зохицуулалт, зөвшөөрөл зайлшгүй шаардах үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай эрхийг цахимаар болон засаг захиргааны анхан шатны нэгжээс шууд олгодог болно.

2.1.3. Гэрээгээр гүйцэтгүүлж болох төрийн бүх чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод үе шаттайгаар шилжүүлэх, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр чиглэлийн, мэргэжлийн төрийн бус, иргэний нигймийн байгууллагуудад шилжүүлнэ.

2.1.4. Төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дараалтыг тогтоож, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ил тод болгож иргэн, аж ахуйн нэгж бизнес, хөрөнгө оруулалтаа төлөвлөх боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.5. Үндэсний баялгийн "Ирээдүйн өв сан"-д ирээдүй үедээ хуримтлал үүсгэж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцанд хөрөнгө оруулалт хийх боломжийг иргэдэд сурталчлан мэдээллийг шуурхай хүргэнэ.

2.1.6. Булган сумын нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт гэрээгээр үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд олгоно.

2.1.7. Оюуны бүтээлийн үнэлэмжийг нэмэгдүүлж, шинэ бүтээл, оюуны өмч, судалгаа шинжилгээ, шинэ технологийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжинэ.

2.1.8. Даатгалын салбарын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, даатгалын

хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг бууруулна.

2.1.9. Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

## 2.2. Дэд бүтэц, эрчим хүч, газар зохион байгуулалт

2.2.1. Сумдад утас, интернет, телевизын гурвалсан үйлчилгээтэй "өрх бүрт интернет" төслийг хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийн интернет үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.2. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцож нөхөн сэргээлтийг хийлгэнэ.

2.2.3. Зүүн түрүүний хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн Хөрөө рамны урдуур оруулан Булган-Эрдэнэтийн засмал замтай холбоно.

2.2.4. Шуудан хүргэлтийг шуурхай, хүртээмжтэй болгож, такси хүргэлтийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлнэ.

2.2.5. Хот хоорондын ачаа, авто тээврийн мэдээллийн нэгдсэн цахим санг ашигладаг болно.

2.2.6. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан болон тодотгол хийх шаардлагатай сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчилнэ.

2.2.7. Дэд бүтцийг улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, хөдөөгийн сумдад иргэд, төрийн албан хаагчдад зориулсан түрээсийн орон сууц барина.

2.2.8. Бүх сумын төвийн дулаан, ус хангамж, ариутгах татуургыг шинээр хийх болон шинэчилж өргөтгөнө.

2.2.9. Бүх суманд рашаан сувилал, зуслан, шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө хийнэ.

2.2.10. Сумдын инженерийн барилга, байгууламжийн зураг төслийг хийлгэж, үерийн далан, сувгийн барилгын ажлыг үе шаттайгаар хийнэ.

2.2.11. Сумдын инженерийн хийцтэй барилга байгууламжуудад үзлэг хийж, гэрчилгээжүүлнэ.

2.2.12. Үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй хөдөөгийн багийн төвүүдийг үүрэн телефоны сүлжээнд бүрэн хамруулж, өндөр хурдны интернэттэй болгоно.

2.2.13. Аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүхий нарийвчилсан мэдээллийн сан байгуулна.

2.2.14. Хутаг-Өндөр, Дашинчилэн, Хишиг-Өндөр зэрэг шаардлагатай сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчилнэ.

2.2.15. Аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдгийг бүртгэлжүүлнэ.

2.2.16. Аймгийн бэлчээрийн газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажлыг хийнэ.

2.2.17. Жаргалант хүүхдийн зуслан руу засмал зам тавина.

2.2.18. Ачаа тээвэр хийдэг жолооч нарт зориулсан цогц үйлчилгээтэй авто зогсоол байгуулна.

## 2.3. Орон сууцтай Булган

2.3.1.“Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Булган сум, хөдөөгийн сумдын иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцыг үе шаттайгаар барина.

2.3.2.Булган сумын иргэд, төрийн албан хаагчдад эхний гурван жилд 3 хувийн зээлийн хүүтэй, ипотекийн зээлийн 6 хувийн хүүтэй орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.3.Булган суманд зорилтот өрхүүдэд зориулсан өртөг багатай түрээсийн орон байрны хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.3.4.Сумын төвүүдэд төрийн албан хаагчийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.5.Ногоон зээлийн санхүүжилтээр гэр хорооллын айл өрхүүдийн амины орон сууцны дулааны алдагдлыг бууруулах бодлого баримтална.

**2.4. “Шинэ хоршоо” хөдөлгөөн:**

2.4.1.“Шинэ хоршоо” хөдөлгөөнийг аймаг, сум, багийн түвшинд өрнүүлж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр малчид нэгдэн хоршиж хөдөлмөрлөхийг дэмжинэ.

2.4.2.Малчдад өвөлжөө, хаваржааны газартаа тэжээлийн ургамал тариалах боломжийг олгон, худаг гаргах, ногоон тэжээл тариалах, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх бодлого баримталж ажиллана.

2.4.3.Орон нутагт дутагдалтай малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтнийг бэлтгэж, давтан сургаж, мэргэшлийг нь дээшлүүлнэ.

2.4.4.Малчдын насан туршийн боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан нийгмийн үйлчилгээг хүргэнэ.

2.4.5.Хоршоололд суурилсан хойд бүсийн загвар хагас эрчимжсэн болон эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.4.6.Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх сум дундын хоршооллыг бүсчлэн байгуулахыг дэмжинэ.

2.4.7.Малчдыг цөөн тоотой, үржил шим өндөртэй нүүдлийн мал аж ахуйд шилжүүлэн, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.4.8.Сум болгонд үржлийн нэгжийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.4.9.Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сумдад үе шаттайгаар нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжинэ.

**2.5. Хөдөлмөр эрхлэлт :**

2.5.1 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг сайжруулж, гадаадын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх зорилтот арга хэмжээг хэрэгжүүлж, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.3 Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.5.4 Жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хөгжүүлэлт хийх чиглэлийг бизнес инкубатор төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.5.5 Газар тариаланг дэмжих цогц үйл ажиллагаа хэрэгжүүлж, хөдөлмөр

эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2.5.6 Хүнсний ногоо дахин боловсруулах цех байгуулан ажлын байр бий болгоно.

2.5.7 Цахим ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.5.8 Үйлдвэрлэл нь эрэлттэй, олон нийтэд танигдсан үйлдвэрлэгчдийг орон нутгийн түвшинд бодлогыг дэмжлэг үзүүлж, дараагийн түвшинд гарах боломжийг бүрдүүлнэ.

2.5.9 Жилд 1500- аас доошгүй байнгын, түр, улирлын ажлын байр бий болгож, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

## 3. ШУДАРГА ЗАСАГЛАЛ – ХАРИУЦЛАГАТАЙ БУЛГАНЧУУД

### 3.1. Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

3.1.1 Цахим хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хариуцлагатай хүргэх тогтолцоог бий болгоно.

3.1.2 "Смарт Булган" (Ухаалаг-Булган) гар утасны программ хөгжүүлэлтийг мэргэжлийн багтай хамтран гүйцэтгэж, хэвийн горимд оруулах, нийгмийн бүхий л салбарыг холбож, ДАН системээр нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.

3.1.3 Иргэд төрийн үйлчилгээг 24 цагийн турш авч болох "Смарт" (Хурдан) төвтэй болно.

3.1.4 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг амаар болон бичгээр авахын зэрэгцээ, 100 хувь цахимд шилжүүлж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээллийг иргэн тогтмол хянах боломжоор хангана.

3.1.5 Засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, түүний удирдлага, материаллаг орчныг бэхжүүлнэ.

3.1.6 Нийгмийн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил иргэдийн санал авах, зөвлөлдөх, шийдвэр гаргахад хяналт тавих нөхцөлийг бүрдүүлнэ.

3.1.7 Иргэн бүр аймгийнхаа ойрын болон хэтийн төлөвлөлт, томоохон төсөл хөтөлбөрт санал өгөх боломжийг бүрдүүлж, оролцоог хангана.

### 3.2. Хүний эрх, иргэний үүрэг

3.2.1. Хүний эрхийг хангах III хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.2.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр аймгийн стратеги төлөвлөгөө боловсруулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

3.2.3. Нутгийн удирдлагын байгууллагын төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд ил тод болгоно.

3.2.4. Нутгийн удирдлагын байгууллагаас иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргах явцад хүний эрхийг хамгаалах байгууллагын болон хамаарал бүхий иргэний нийгмийн байгууллагын санал, дүгнэлтийг авдаг болно.

3.2.5. Эрх зүйн боловсролын "Үүргээ биелүүлж, эрхээ эдэлдэг хариуцлагатай Булганчууд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2.6. Аймагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн явц, гүйцэтгэлийн талаар "Нээлттэй сонсгол" явуулах журам боловсруулж мөрдөнө.

### 3.3. Шударга, хариуцлагатай нутгийн удирдлага

3.3.1. ОХУ-ын Буряд улс, БНСУ, БНХАУ зэрэг улс орнуудад оюутан сургах,

төлөөлөгч солилцох, туршлага судлах, төсөл хөтөлбөрүүд хамтран хэрэгжүүлж хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

3.3.2. Нутгийн удирдлагын нэгдмэл байдлыг хангаж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллана.

3.3.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын харьцангуй бие даасан байдлыг бэхжүүлнэ.

3.3.4. Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлан “Булган аймгийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” боловсруулна.

3.3.5. Төрийн албаны оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий төрийн албыг бэхжүүлж, цахим технологийг нутагшуулж, иргэн төвтэй төрийн албыг бий болгоно.

3.3.6. Төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг тухайн ажлын байрны чиглэлийн дагуу гадаад улс оронд богино болон урт хугацаанд суралцуулах, туршлага судлах, эргээд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, дэмжинэ.

3.3.7. Төрийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг үнэлж, шаардлагатай чиглэлээр чадваржуулах, мэргэшүүлэх, мэдлэг чадварын түвшинг нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ.

3.3.8. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, орон нутагт шилжин ирэх бодлогыг дэмжинэ.

3.3.9. Орон нутагт дутагдалтай мэргэжлээр ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг сургах замаар хүний нөөцийн дутагдлыг арилгах урт хугацааны бодлого баримталж, арга хэмжээ авч ажиллана.

3.3.10. Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлогыг баримтална.

3.3.11. Татварын хөнгөлөлтийн 6 хүртэлх сая төгрөгийг орон сууцны урьдчилгаанд тооцуулах, батлан даах боломжийг бүрдүүлнэ.

3.3.12. Төрийн албан хаагчдыг нийгэмд ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх тогтолцоог бэхжүүлнэ.

3.3.13. Төрийн албанаас улс төрийн шалтгаанаар ажилтныг чөлөөлөх, халах явдлыг таслан зогсооно.

3.3.14. Төрийн албаны нийтлэг үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлнэ.

3.3.15. Иргэдийн индэр нээлттэй хэлэлцүүлгийг 14 хоногт нэг удаа зохион байгуулж, иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг хүлээн авч иргэндээ ойр төрийн албыг бий болгоно.

# 4. НОГООН ХӨГЖИЛ – ЭКО БУЛГАНЧУУД

## 4.1. Байгаль орчин

4.1.1. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг хийж, ховордсон зүйлийн улаан дансны үнэлгээг шинэчлэн тогтоож хамгаална.

4.1.2. Булган аймгийн амьтан, ургамлын тархац, тоо толгой, нөөц ашиглалтын судалгааг хийж, хамгаалах бодлого боловсруулна.

4.1.3. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.4. Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин, аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлнэ.

4.1.5. Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах замаар ашиглагч малчдыг хариуцлагажуулж, бэлчээрийн доройтлыг бууруулна.

4.1.6. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

4.1.7. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

4.1.8. Аж үйлдвэрийн бүс, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Үйлдвэр технологийн паркаас уул уурхайн үйлдвэрлэлийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус ашиглах зэргээр хамтын ажиллагааг сайжруулна.

4.1.9. Хог хаягдлыг дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөгүй аргаар устгах , ашиглах санаачилгуудыг дэмжин байгальд ээлтэй техник технологийг нэвтрүүлнэ.

4.1.10. Бугын аж ахуй зэрэг зэрлэг ан амьтадыг өсгөн үржүүлэх, зохист ашиглалт, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийн суурь судалгааг хийж эхлүүлнэ.

### 4.2. Хариуцлагатай уул уурхай

6317144798
ГЮА0048 3190269

4.2.1. Уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас үүдэх байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

4.2.2. Хариуцлагатай уул уурхайг дэмжиж, аймгийн хэмжээнд уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг хуулийн хүрээнд хяналт тавьж, хамтран ажиллана.

4.2.3. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулж боловсрол, эрүүл мэндийн салбаруудад тулгамдаж буй асуудлуудад хөрөнгө оруулалт хийж ажиллана.

4.2.4. Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийн нөхөн сэргээлтийн ажлуудыг бүрэн хийлгэнэ.

4.2.5. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулна.

### 4.3. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдал

4.3.1. Бүсчилсэн хөгжлийн бодлого, Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүнд Булган аймгийн иргэдийг хямд чанартай, эрүүл, аюулгүй дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3.2. Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3.3. Хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, тээвэрлэлт, хадгалалтад онцгой анхаарч, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлнэ.

4.3.4. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогыг тэргүүлэх зорилгын нэг болгон хэрэгжүүлэхийн чацуу, бүсийн хэмжээнд сав баглаа боодлын үйлдвэрийг байгуулна.

4.3.5. "Хөрс эрүүл бол Хүнс эрүүл", "Хүнс эрүүл бол Хүн эрүүл" компанит ажлыг жил бүр зохион байгуулж, иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.

4.3.6. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлд хойд бүсээс сонгогдсон гишүүдэд орон нутгийн үйлдвэрлэгчдийн саналыг уламжилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

4.3.7. Газар тариалан болон хүнсний ногооны тариалалт дээр хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх ажилд онцгой анхаарч, нэмэгдүүлнэ.

4.3.8. Шинэ хөдөө Булган хөтөлбөрийг үргэлжлүүлж, дундын түрээс техник тоног төхөөрөмжийн бааз суурь бүхий дэмжих төвийг байгуулна.

4.3.9. Бордооны ашиглалт дээр хяналт тавьж, судалгаанд суурилан нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

4.3.10. Хүнсний нарийн ногоо, жимс, жимсгэнэ тариалах 4 улирлын турш сэргээгдэх эрчим хүчээр ажиллах, ухаалаг хүлэмжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар барьж байгуулна.

**4.4. Ногоон байгууламж**

4.4.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөөтэй уялдуулан 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлнэ.

4.4.2. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлж, хамгаалах менежментийг сайжруулан, ойн хомстол, доройтлыг бууруулна.

4.4.3. Иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай ногоон орчныг нэмэгдүүлнэ.

6317144798
ПОА0048 3190269

4.4.4. Усны нөөцийг бохирдох, хомсдохоос сэргийлж, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоож, бүсийн дэглэмийг мөрдүүлнэ.

4.4.5. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг батлуулна.

4.4.6. Хавар, намрын хуурайшилт ихтэй үед ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг мэдээллийн бүхий л хэрэгслээр ард иргэдэд хүргэнэ.

4.4.7. Гудамж талбайн цэвэрлэгээ, хог ачиж цуглуулах үйлчилгээнд тусгай зориулалтын тоног төхөөрөмжтэй машин техникийг нэвтрүүлнэ.

4.4.8. Хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

4.4.9. Хөрсний бохирдол, түүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, нүхэн жорлонг био жорлонгоор солих ажлыг бүсчилсэн байдлаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**4.5. Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.**

4.5.1. Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

4.5.2. Орон нутгийн эмзэг байдлын үнэлгээ хийнэ.

4.5.3. Мэргэжлийн анги, сайн дурынхныг чадавхжуулах ажлыг зохион байгуулна.

4.5.4. Агуулахын аж ахуйг хөгжүүлж, шаардлагатай бараа, материалын нөөц бүрдүүлнэ.

4.5.5. Бүсийн сумдын дунд онцгой байдлын салбарыг байгуулна.

4.5.6. Аймаг, сумын онцгой байдлын одоогийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ

хийж, ган зуд, үер ус гэх зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг багасгах, эрсдэлийг бууруулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

# 5. БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ – АЗ ЖАРГАЛТАЙ БУЛГАНЧУУД

## 5.1. Бүсчилсэн хөгжил – Булганы сэргэлт

5.1.1. "Эрдэнэт цогцолбор" дээд сургуульд Булган аймгийн шалгуур хангасан оюутнуудыг сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх бодлогыг баримталж орон нутгийн хүний нөөцийн бодлогыг бэхжүүлнэ.

5.1.2. Хойд бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан элсүүлэх мэргэжлийн нэр төрлийг нэмэгдүүлж, аймгийн Политехник коллежид дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулна.

5.1.3. Хог хаягдал ангилан ялгах цехийг Булган аймгийн төвд төвлөрүүлэн байгуулна.

5.1.4. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хагас болон гүн боловсруулах хөнгөн үйлдвэрийг цогцолборыг Булган аймагт үе шаттайгаар байгуулах ажлыг эхлүүлнэ.

5.1.5. Махны үйлдвэр, ноосны үйлдвэрийг бүсчилсэн хэлбэрээр, оновчтой байршилд байгуулна.

6317144798
ГЮА0948 3196269

5.1.6. Стратегийн ач холбогдол бүхий сумдыг газар тариалан, мал аж ахуй, хүнсний хөнгөн үйлдвэрлэлээр хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

5.1.7. Хөвсгөл, Булган, Сэлэнгэ аймаг, Дархан, Эрдэнэт хотын нутаг дэвсгэрийг хамарсан Дархадын хотгор, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав дагуух экосистемд түшиглэсэн байгалийн олон төрөлт, хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын чиглэлийг хөгжүүлэх ХӨХ БААВГАЙ кластерт нэгдэнэ.

## 5.2. Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр

5.2.1. Хөдөө аж ахуйн салбарыг шинэ технологи инновацад суурилан хөгжүүлж, цаг уурын эрсдэлд дасан зохицсон, үр ашигтай бизнесийн салбар болгон хөгжүүлнэ.

5.2.2. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

5.2.3. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, халдварын бүс бүс нутгийг тусгаарлан, холбогдох арга хэмжээг авч тархалтыг зогсоож, эрүүлжүүлнэ.

5.2.4. Малын эрүүл мэндийг хамгаалах цогц урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, мал, амьтны гоц халдварт өвчний вакцинд бүрэн хамруулж, мал, амьтны өвчний тархалтыг хязгаарлана.

5.2.5. Малын ашиг шим, үржил селекцийг сайжруулан малын тооноос чанарт анхаарч, орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох, үржлийн аж ахуйг бүсчилж байгуулна.

5.2.6. Малын тоо толгойн албан татварын зарцуулалтыг ил, тод болгон малчдад

тайлагнаж, цаашдын хөгжлийн төлөвлөлтийг малчдын оролцоотой шийдвэрлэнэ.

5.2.7. Атаршиж өнжөөсөн талбайг малчдын хоршоонд олгох замаар ногоон тэжээл тариалалтыг нэмэгдүүлж, байгалийн эрсдэл, ган, зудыг даван туулах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.8. Гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.

5.2.9. Чацаргана, зөгийн бал боловсруулах цех, модон материал, модон сав суулга, тавилгын үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлнэ.

5.2.10. Хүлэмж, агуулах, зоорины аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлж, бүс нутгийн хэрэгцээг хангах, жилийн дөрвөн улиралд тасралтгүйгээр орон нутагт нийлүүлэлт хийх, эрүүл, аюулгүй хүнсээр хангах ажлыг үе шаттайгаар эхлүүлж, хэрэгжүүлнэ.

5.2.11. Хөрс, цаг уурын онцлогт тохирсон дотоодын баталгаат сортын үрийн хангамж, тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

5.2.12. Газар тариалангийн ангилалт, нөөцийг сайжруулан орон нутгийн хөрсөнд тарьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн “Атар IV” аяныг хэрэгжүүлнэ.

5.2.13. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тулгуурлан төрөлжүүлэн хэрэгжүүлнэ.

5.2.14. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогын тогтвортой байдлыг хангах орон нутгийн тусгай бодлого боловсруулна.

6317144798
ГЮА0048 3190269

## 5.3. Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл

5.3.1. Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг сайжруулж, олон улсын түвшинд үе шаттайгаар хүргэнэ.

5.3.2. Аялал, жуулчлалын чиглэлээр нэн шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэж, бүсчилсэн хөгжлийг бодлогот суурилсан рашаан, сувилал, түүх соёлын, байгалийн, адал явдалт аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлнэ.

5.3.3. Аймаг, орон нутгийн соёлын онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, нийлүүлэлтийг сайжруулан, аялал жуулчлалд тулгуурласан ЖДҮ-ийг хөгжүүлэн орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

5.3.4. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжинэ.

5.3.5. Аялал жуулчлалын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

5.3.6. Аялал жуулчлалаар зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, голлох зам, амрах өртөө, түр отоглох цэг, үйлчилгээний цогцолборын үйлчилгээг дэмжиж стандартад нийцүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.3.7. Эко бааз, ногоон гэрчилгээжүүлэлтийг нэвтрүүлж жорлонгоо өөрчилье, хогоо шийдье уриан дор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

5.3.8. Тусгай сонирхлын (шувуу, цэцэг ажиглах аялал болон ангийн аялал) аялал жуулчлалыг хөгжүүлж орлого олох боломжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

5.3.9. Булган аймгийн аялал жуулчлалд эзлэх байр суурийг бэхжүүлж, дамжин өнгөрөх бус, буудлах, хоноглох төлөвт шилжүүлэн, соёлын олон төрөлт бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ.

5.3.10. Малчин өрхийн нэмэлт орлогыг нэмэгдүүлэх хүрээнд Булган аймагт аялал жуулчлалын шинэ багц "нэг айл – нэг илүү гэр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.3.11. Булган аймгийн онцлог, соёлын өв уламжлалыг сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

5.3.12. Аймгийн соёлын брэнд "Айраг фиставаль", " Хангинахын шугуйн тойром", "Алтаргана наадам" зэрэг уламжлалт эвент арга хэмжээг сайжруулан зохион байгуулахын зэрэгцээ шинэ эвент арга хэмжээг хөгжүүлнэ.

5.3.13. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээнд цахим дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

**5.4. Амар тайван, аюулгүй аймаг**

5.4.1. Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөрийг эрчимжүүлж, төр иргэнээс нэг удаа мэдээлэл авдаг тогтолцоонд шилжүүлнэ.

5.4.2. Аймагт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож, мэдээлэл, харилцаа холбоо, барилга байгууламжийн дэд бүтцийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.

5.4.3. Хуулийн салбарын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилнэ.

5.4.4. Аймгийн Төрийн архивыг стандартын шаардлага хангасан шинэ байр барьж оруулна.

6317144798
ПЮА0048 3190269

5.4.5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн хяналтын механизмыг бий болгож авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

5.4.6. Бүх нийтээр авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлнэ.

**5.5. Эрүүл идэвхтэй амьдрал**

5.5.1. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, орон нутгийн тамирчдыг дэмжинэ.

5.5.2. Булган суманд биеийн тамир, спортын орчин нөхцөл, талбай бүхий дэд бүтцийг бий болгоно.

5.5.3. Хөдөлгөөний хомсдолоос сэргийлж аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан дасгал, хөдөлгөөн, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшүүлнэ.

5.5.4. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.5.5. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг сайжруулах, зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

## 6. БУЛГАНЫ СЭРГЭЛТ – СУМЫН ХӨГЖИЛ

### 6.1. Баян-Агт сум

6.5.1. Баян-Агт сумын 240 суудалтай сургуулийн өргөтгөл болон цэцэрлэгийн өргөтгөл

6.5.2. Гурванбулаг сумаас Могод, Дондогийн булгаас Сайхан, Баян-Агт, Хялганатаас Сэлэнгэ сум хүртэл авто зам тавих асуудлыг судалж ТЭЗҮ хийлгэнэ.

6.5.3. Баян-Агт суманд "Орон нутаг судлалын танхим" байгуулна.

6.5.4. Хануй болон Цагаан голын рашаан сувиллын бүс нутагт орон нутгийг иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

6.5.5. Сумын сургуулийн багш нарын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг сайжруулж, чадавхжуулна.

### 6.6. Баяннуур сум

6.6.1. Баяннуур 80 ортой дотуур байр барина.

6.6.2. Баяннуур сумыг ЭМТ-ийг тусгай зориулалтын яаралтай тусламжийн авто машинаар хангана

6.6.3. Баяннуур суманд "Орон нутаг судлалын танхим" байгуулна.

6.6.4. Баяннуур суманд усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэдийн ундны ус, мал аж ахуйн усан хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.6.5. Малын бэлчээрийн менежментийг сайжруулан, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

### 6.7.Бугат сум

6.7.1. Эрдэнэт-Булганы авто замаас Тарвагатайгаар Бугат сумын төв хүртэл 25 км хатуу хучилттай авто зам тавина.

6.7.2. Бугат суманд "Орон нутаг судлалын танхим" байгуулна.

6.7.3. Сумын байгалийн үзэсгэлэнт газруудад орон нутгийг иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

6.7.4. Сүү сүүн бүтээгдэхүүн, малын гаралтай түүхийн эд бүтээгдэхүүн, цагаан идээ боловсруулах бичил өрхийн үйлдвэрлэлийг дэмжинэ.

6.7.5. Орон нутгийн иргэд, малчдыг нэгдэн хоршиж хөдөлмөрлөхийг дэмжиж, арьс шир боловсруулах, мал мах бордох, малын тэжээл, төмс хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг дэмжинэ.

### 6.4.Бүрэгхангай сум

6.4.1. Бүрэгхангай сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгыг барина.

6.4.2. 35 кВ-ын Бүрэгхангайн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилнэ.

6.4.3. Суманд жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

6.4.4. Тэжээлийн ургамал тарих, хадлан бэлтгэх, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нутгийн иргэд, малчдын хоршин хөдөлмөрлөхийг дэмжинэ.

6.4.5. Сумын сургуулийн багшийн хангамжийг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.

### 6.5.Гурванбулаг сум

6.5.1. Гурванбулаг цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг барина.

6.5.2. Баруун бүсийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай Булган-Орхон-Хишиг-

6317144798

Өндөр-Гурванбулаг сумын хатуу хучилттай, замын ажлыг гүйцээнэ.

6.5.3. Гурванбулагаас Рашаант, Могод, Тарнийн гүүрийг холбох хатуу хучилттай замын ТЭЗҮ-ийг боловсруулна.

6.5.4. Гурванбулаг сумын хүн амыг шаардлага хангасан ундны усаар хангана.

6.5.5. Нүүдлийн МАА-д түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлого, эрх зүйн орчны дэмжлэг үзүүлнэ.

**6.6.Дашинчилэн сум**

6.6.1. Дашинчилэн сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг тус тус барина.

6.6.2. Мянганы болон босоо тэнхлэгийн хатуу хучилттай зам дагуу Олон улсын жишигт хүрсэн эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг Дашинчилэн сумын ЭМТ-д үзүүлдэг болно.

6.6.3. Дашинчилэн суманд "Ахмадын өргөө", "Соёл, спортын цогцолбор", "Орон нутаг судлалын танхим" барина.

6.6.4. Дашинчилэн сумын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилнэ.

6.6.5. Дашинчилэн суманд усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэд ундны ус, мал аж ахуйн усан хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.6.6. Орон нутгийн иргэд, малчдыг нэгдэн хоршиж хөдөлмөрлөхийг дэмжиж хужир бэлтгэх, жимс, хүнсний ногоо тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.

6317144798
ГЮА0048 3198269

**6.7. Могод сум**

6.7.1. Могод суманд цэцэрлэгийн өргөтгөлийг барьж, сургуулийн биеийн тамирын заалыг стандартад нийцүүлэн шинэчилнэ.

6.7.2. Могод ЭМТ-ийн өргөтгөл, "Ахмадын өргөө", Соёл, спортын цогцолборыг барина.

6.7.3. Гурванбулаг сумаас Могод авто зам тавих асуудлыг судалж ТЭЗҮ хийлгэнэ.

6.7.4. Могод суманд 1 мВт нарны сэргэгдэх эрчим хүчний батарей станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барина.

6.7.5. Могод суманд усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэд, мал аж ахуйн усан хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.7.6. Нутгийн брэнд айраг, халуун рашаан, байгалийн үзэсгэлэнт газруудад түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

**6.8. Орхон сум**

6.8.1. Орхонд биеийн тамирын заалтай, 240 суудалтай сургуулийн хичээлийн байрыг ашиглалтад оруулна.

6.8.2. Баруун бүсийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сумын хатуу хучилттай, замын ажлыг гүйцээнэ.

6.8.3. 10 кВ-ын Орхон сумын цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетонон тулгуурт шилжүүлэх

6.8.4. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зам дагуу "Эко" бие засах газар барина.

6.8.5. Жижиг дунд үйлдвэрлэл, малчдын хоршоог бодлогоор дэмжиж ажиллана.

**6.9. Рашаант сум**

6.9.1. Рашаант сумын цэцэрлэгийн өргөтгөл, "Ахмадын өргөө" "Орон нутаг

судлалын танхим”-ын барилгыг тус тус барина.

6.9.2. Рашаант ЭМТ-ийг тусгай зориулалтын яаралтай тусламжийн авто машинаар хангана.

6.9.3. Гурванбулагаас Рашаант, Тарнийн гүүрийг холбох хатуу хучилттай замын ТЭЗҮ-ийг боловсруулна.

6.9.4. 2,2 мВт -ын нарны сэргэгдэх эрчим хүчний батарей станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барина.

6.9.5. Усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан санг байгуулж, ард иргэд, мал аж ахуйн усан хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.9.6. Хөгнө, Тарна, Элсэн тасархайн байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэсэн аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлнэ.

**6.10. Сайхан сум**

6.10.1. Сумын биеийн тамирын заалтай 320 суудалтай сургуулийн байр, 80 ортой дотуур байрыг тус тус ашиглалтад оруулна.

6.10.2. Сайхан сумын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилнэ.

6.10.3. Дондогийн булгаас Сайхан авто зам тавих асуудлыг судалж ТЭЗҮ хийлгэнэ.

6.10.4. Сайхан сумын брэнд айраг, адууны өв соёлд суурилсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлээр айргийн хөргүүр, савлах үйлдвэрийг ашиглалтад оруулна.

**6.11. Сэлэнгэ сум**

6.11.1. Хялганатаас Сэлэнгэ сум хүртэл авто зам тавих асуудлыг судалж ТЭЗҮ хийлгэнэ.

6.11.2. Сэлэнгэ сумын төвийн гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэж иж бүрэн зураг, төсөл боловсруулан хамгаалалтын арга хэмжээ авна.

6.11.3. Зөгийн аж ахуй, ногоон тэжээл, төмс, хүнсний ногоо, халтар арвай тарихад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

6.11.4. Махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн цөм сайжруулж, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлнэ.

**6.12. Тэшиг сум**

6.12.1. Тэшиг сумын Бага - Илэнхийн боомтыг нээж, байнгын ажиллагаатай болгон, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

6.12.2. Нутгийн брэнд цөцгий, масло, буриад талх, бяслаг, зөгийн балыг үйлдвэрлэлийн хэмжээнд хөгжүүлнэ.

6.12.3. Тэшиг, Сайхан сумын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилнэ.

6.12.4. Тэшиг суманд 1 мВт нарны сэргэгдэх эрчим хүчний батарей станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барина.

6.12.5. Малын бэлчээрийн менежментийг сайжруулан, байгаль цаг уурын эрсдэлээс сэргийлж, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлэх чиглэлд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

6.12.6. Малын хулгайтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, гүүрний байнгын посттой болно.

**6.13. Хангал сум**

6.13.1. Суманд ЭМТ-ийн шинэ барилга, 80 ортой дотуур байр барьж, “Орон нутаг судлалын танхим” -ийг байгуулан сургуулийн биеийн тамирын заалны

шинэчлэлийн ажлыг эхлүүлнэ.

6.13.2. Сургуулийн багш, ЭМТ-ийн их эмч, сувилагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг хангана.

6.13.3. Төмс, хүнсний ногоо, сүү цагаан идээгээр Эрдэнэт хотыг хангах чиглэлд анхаарч ажиллана.

6.13.4. Зөгий, тахианы аж ахуйг хөгжүүлж, малын ногоон тэжээл, халтар арвай, бог будааны тариалалтыг бодлогоор дэмжинэ.

**6.14. Хялганат тосгон**

6.14.1. Хялганат тосгоны ЭМТ-ийн өргөтгөл, "Соёл, спортын цогцолбор" -ын барилгыг барьж, ЭМТ-ийг яаралтай тусламжийн авто машинаар хангана.

6.14.2. Хялганатаас Сэлэнгэ сум хүртэл авто зам тавих асуудлыг судалж ТЭЗҮ хийлгэнэ.

6.14.3. Хялганат тосгоны хүн амыг шаардлага хангасан ундны усаар хангана.

6.14.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, Хялганат тосгоны дэд бүтцэд түшиглэн иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.

6.14.5. Аялал жуулчлалын одоогийн суурь дээр тулгуурлаж нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлнэ.

**6.15. Хишиг-Өндөр сум**

6.15.1. Хишиг-Өндөрт "Соёл, спортын цогцолбор", биеийн тамирын заалтай, 640 суудалтай сургуулийн хичээлийн байр, 80 ортой дотуур байрыг тус тус барина.

6.15.2. ЭМТ-ийг зөөврийн рентген аппараттай болгон, эмч мэргэжилтнийг сургаж бэлтгэж, тусгай зориулалтын яаралтай тусламжийн авто машинаар хангана.

6.15.3. Баруун бүсийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сумын хатуу хучилттай, замын ажлыг гүйцээнэ.

6.15.4. Хишиг-Өндөр сумын шинэ суурьшлын бүсэд 35/0,4 кВ-ын дэд станц барина.

6.15.5. 2,2 мВт -ын нарны сэргэгдэх эрчим хүчний батарей станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барина.

6.15.6. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, хувийн хэвшлийн туслалцаатайгаар Хишиг-Өндөр суманд бүсчилсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж бугын, зөгийн аж ахуйг сэргээх ажлыг бодлогоор дэмжинэ.

**6.16. Хутаг-Өндөр сум**

6.16.1. ЭМТ-ийг зөөврийн рентген аппараттай болгон, эмч мэргэжилтнийг сургаж бэлтгэж, тусгай зориулалтын яаралтай тусламжийн авто машинаар хангана.

6.16.2. Суманд "Соёл, спортын цогцолбор"-ийг шинээр барьж, "Орон нутаг судлалын танхим" байгуулна.

6.16.3. Босоо тэнхлэгийн Бага-Илэнх боомт-Булган аймгийн Хутаг-Өндөр чиглэлийн 146 км хатуу хучилттай авто замыг барина.

6.16.4. 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилнэ.

6.16.5. Малын бэлчээрийн менежментийг сайжруулан, байгаль цаг уурын эрсдэлээс сэргийлж, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

**6.17. Булган сум**

6.17.1. Сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих асуудлыг судлан

шийдвэрлэнэ.

6.17.2. Түлээний зах болон худалдааны төвийг байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

6.17.3. “Өрхийн эрүүл мэндийн төв/ цогцолбор/ ”-ийн барилгыг барьж, нэн шаардлагатай сэргээх засах үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, Монгол Улсын жишиг загвар төв болгоно.

6.17.4. Диваажингийн сүм, Баруун замын байлдааны штаб музей, Ардын Хатанбаатар Магсаржавын дуулгат бунхан тохижилтын ажил хийж, үзүүлэг дэглэлтийг шинэчилнэ.

6.17.5. Биеийн тамир, спортын орчин нөхцөл, талбай бүхий дэд бүтцийг бий нэмэгдүүлнэ.

6.17.6. “Саятны цагаан хаалга”-наас Вангийн хүрээний хийд- “Нууц булаг” “Нарлаг” шинэ суурьшлын бүсийг Ачуут голын гүүртэй холбох хатуу хучилттай замын ТЭЗҮ-г хийнэ.

6.17.7. Гудамж талбай, нийтийн эзэмшлийн гэрэл гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон хэмнэлттэй, ухаалаг системээр үе шаттай шинэчлэх арга хэмжээ авна.

6.17.8. Залуус хорооллын цэвэр ус, дулаан, бохирын шугам сүлжээг үе шаттайгаар ашиглалтад оруулна.

6.17.9. “Нууц булаг”, “Нарлаг” шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөөг хийлгэж, дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

6.17.10. Ачуутын голын ай сав газарт инженерийн биет судалгаа, зураг төсөл хийлгэж, далан суваг барина.

6.17.11. Булган сумын одоо ашиглаж байгаа инженерийн байгууламжуудад үзлэг хийн дүгнэлт гарган шинэчлэх ажлыг үе шаттайгаар хийж, байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зурагтай болно.

6.17.12. Орон сууц барих газрын инженерийн дэд бүтцийг эхний ээлжид улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 300-аас доошгүй айлын орон сууц барина.

6.17.13. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, Булган сумын дэд бүтцэд түшиглэн иргэдийг хямд, чанартай мах, сүү, хүнсний ногоогоор хангана.

6.17.14. Булган суманд Гэрлэх ёслолын өргөө барина.